



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 0/145

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр тогтоол, 2021 оны 78 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/61 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан "Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн боловсролын газрын ажиллах үлгэрчилсэн журам"-ын 2.3.2 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын Физикийн 34 дүгээр олимпиадыг зохион байгуулахад шаардагдах 30,000,000 (гучин сая) төгрөгийг "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн батлагдсан зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

2. Олимпиадыг чанартай зохион байгуулж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал), Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

0201000905